



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/63

Пионер толгой

Г Сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг Г  
ослын үеийн удирдлагын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж,  
стратегийн команд штабын дадлага, сургуульд  
бэлтгэл ажлыг хангаж оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 зүйлийн 271.1.4, 271.1.6, 28 дугаар зүйлийн 28.1.5, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3, 32.1.5, 32.1.8, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12/54 тогтоолын хавсралтаар батлагдсан 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.7 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран Улсын хэмжээнд зохион байгуулах “Стратегийн команд штаб”-ын дадлага, сургуульд оролцохтой холбогдуулан сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг ослын удирдлагын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж хавсралтаар баталсугай.

2. Улсын хэмжээнд зохион байгуулагдах “Стратегийн команд штаб”-ын дадлага, сургуульд сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах албад мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүнийг бүрэн хамруулж, идэвх оролцоо, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой комиссын нийт гишүүдэд

3. “Стратегийн команд штаб”-ын дадлага, сургуулийн хүрээнд гамшгийн аюулын зарлан мэдээлэх дохиогоор ажиллах дадлага, сургуулийг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт Улсын хэмжээнд зохион байгуулах тул иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд тусгай тэмдэглэгээ бүхий “Түр цугларах цэг”-т холбогдох зааврын дагуу гарч дадлага, сургуулилт хийхийг иргэд, аж ахуй нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт

4. Дадлага, сургуулийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад газар хөдлөлтийн гамшгийн аюулыг таниулах “Бэлэн бай” аян, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор ажиллах дадлага, сургуулийг хийхтэй холбогдсон мэдээлэл, сурталчилгааны хэвлэмэл болон

видео шторкуудыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 (Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо нь өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй)-т заасны дагуу тухай бүр үнэ төлбөргүй, өдөр бүр олон удаагийн давтамжтайгаар иргэд, олон нийтэд шуурхай хүргэж, сурталчилж ажиллахыг онцгой комиссын гишүүд, баг, байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга (Р.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Э.СҮГЛЭГМАА